



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Ардчилсан намын дарга
өөрчлөгдсөнийг бүртгүүлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Х.Батсүрэн, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар, Ардчилсан намын дарга өөрчлөгдсөнийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Б.Амарбаясгалангийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Ардчилсан намын дарга Л.Гантөмөрөөс 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр Улсын дээд шүүхэд гаргасан өргөдөлдөө: “Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооноос сонгож, намын Их хурлаас батламжилсан тул Одонгийн Цогтгэрэлийг Ардчилсан намын даргаар бүртгэж өгнө үү” гээд нийт 364 хуудас материалыг 1 ширхэг флашны хамт ирүүлсэн ба өргөдлийг шалгах ажиллагааны явцад дахин 1 ширхэг флаш, 904 хуудас баримтыг нэмэлтээр ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтуудыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу шалгаж, нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцсэн болно.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр Ардчилсан намын даргаар О.Цогтгэрэлийг бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна”, 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана:” гээд 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам”, 15.2.5-д “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”, 17 дугаар зүйлийн 17.2-т

“Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гээд 17.2.4-д “Намын дүрэмд заасан бусад асуудал”, 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... сонгоно” гэж тус тус заажээ.

Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооноос /цаашид “ҮБХ” гэх/ намын даргыг сонгож, Ээлжит бус Их хурлаас батламжилсан үйл ажиллагаа нь хуулийн дээрх зохицуулалт болон Улсын дээд шүүхэд бүртгэлтэй тухайн намын дүрэмд нийцсэн байна.

Нэг.Намын төлөөллийн төв болон удирдах дээд байгууллагыг зарлан хуралдуулсан процессын талаар:

Ардчилсан намын дүрмийн 5.12.2-т “Их хурлын ээлжит хуралдаан дөрвөн жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Их хурлын ээлжит, ээлжит бус хуралдааныг ҮБХ-ны нийт гишүүдийн ердийн олонхи /50-аас дээш хувь/-ийн саналаар эсвэл Намын дарга зарлан хуралдуулна”, 5.17.1-д “Ардчилсан намын дарга нь намын тэргүүн бөгөөд Үндсэн дүрэм, бусад журмын хүрээнд тушаал, шийдвэр гаргана”, 5.17.4-т “Намын даргын эрх”, 5.17.4.2-т “Их хурлыг зарлан хуралдуулах”, 5.17.4.11-д “Бүх шатны намын байгууллагын хуралд оролцох, хуралдуулах” талаар заажээ.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтаас үзэхэд, Ардчилсан намын дарга Л.Гантөмөр нь намын ҮБХ-ны хурлыг 2025 оны 08 дугаар сарын 28-нд, Ээлжит бус Их хурлыг 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдөр тус тус хуралдуулахаар 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/10, А/12 дугаар тушаалыг гаргасан нь намын даргын эрх хэмжээний хүрээнд хамаарч байна.

Тус намын дарга Л.Гантөмөрөөс намын даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн ҮБХ-ны хуралд гаргасныг уг хороо хэлэлцээд тухайн албан тушаалаас чөлөөлсөн 19 дүгээр тогтоолыг гаргасан нь намын дүрмийн 5.17.6-д “Намын даргыг дараах үндэслэлээр ҮБХ-ны хурлаар чөлөөлж намын Их хурлыг зарлана. Энэ тохиолдолд чөлөөлөгдсөн намын дарга нь АН-ын Үндсэн дүрмийн 5 дугаар бүлгийн 5.12.4.8 дахь хэсэгт заасны дагуу батламжлагдаж, шинээр сонгогдсон намын даргад эрх үүргээ шилжүүлснээр бүрэн эрх нь дуусгавар болно. Үүнд:” гээд 5.17.6.2-т “Чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан” гэж заасантай нийцсэн байх бөгөөд намын даргыг сонгох, чөлөөлөх эрх нь намын Үндэсний бодлогын хороонд олгогджээ.

Түүнчлэн, намын ҮБХ, Ээлжит бус Их хурлыг товлон зарлах болон хуралдааны товыг намын гишүүд, төлөөлөгчдөд журамд заасан хугацаанд, нийгмийн сүлжээн дэх тухайн намын цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн болох нь тогтоогдсон болно.

Хоёр.Төлөөллийн төв байгууллага болох Үндэсний бодлогын хороо, тус хорооноос намын даргыг сонгосон талаар:

1.Өргөдөлд хавсаргасан баримтуудаас үзэхэд, Ардчилсан намын Их хурлын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Үндэсний Бодлогын Хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай” 07 дугаар тогтоолын хавсралтаар Үндэсний бодлогын хорооны 363 гишүүнийг баталжээ.

2.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгож хүндэтгэн үзэх бөгөөд тодорхой асуудлыг дийлэнх олонхын саналаар шийдвэрлэхээр намын дүрэмд зааж болно”, 17 дугаар зүйлийн 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... сонгоно” гэж;

Ардчилсан намын дүрмийн 4.1-д “Бүх шатны намын байгууллага, гишүүд аливаа асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхдээ олонхоороо шийдвэр гарган, цөөнхийн саналыг хүндэтгэлтэй сонсон хуралдааны тэмдэглэлд тусгаж, нийтээрээ даган мөрдөх нэгдмэл зарчмыг баримтална”, 4.3.4-т “Аливаа сонгуультай холбоотой намын гишүүний асуудлыг өрсөлдөгчгүй тохиолдол биш бол нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах эсвэл санал нэгдэх замаар шийдвэрлэнэ”, 4.3.5-д “Хурлын ирц дараах байдлаар бүрдэнэ. Үүнд:” гээд, 4.3.5.1-д “Бүх шатны намын байгууллагын хурлын хувьд Үндсэн дүрэм, бусад журамд өөрөөр заагаагүй бол таслах эрхтэй нийт гишүүдийн ердийн олонх”, 4.5-д “Бусад тохиолдолд хурлын шийдвэр нь Үндсэн дүрэм, бусад журамд өөрөөр заагаагүй бол хуралд оролцогчдын ердийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно” гэж тус тус заасан.

Тус намын ҮБХ-ны 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “Хуралдааны бүрэн эрхийг батлах тухай” 13 дугаар тогтоол, хурлын тэмдэглэлд “363 гишүүн хуралдаанд оролцохоос 250 гишүүн хүрэлцэн ирж, ирц 69 хувьтай байна” гэж, харин хурлыг завсарлуулж, 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдөр үргэлжлүүлэн явуулахдаа ирцийн талаар дурдаагүй байгаа боловч ҮБХ-ны Дотоод сонгуулийн хорооны Тооллогын комиссын 01 дүгээр тогтоолоор 314 гишүүн намын даргын сонгуульд оролцож, нууцаар санал өгсөн нь тогтоогдож байх тул ҮБХ-ны гишүүдийн ердийн олонх оролцсон гэж үзэх үндэслэлтэй.

3.Уг сонгуульд 5 гишүүн нэр дэвшүүлэх хүсэлт гаргаснаас 4 гишүүнийг бүртгэж, нэр дэвшигчийн үнэмлэх олгон, 1 гишүүнийг бүртгэхээс татгалзсан ба ҮБХ-ны 314 гишүүн нууцаар санал өгснөөс нэр дэвшигч Одонгийн Цогтгэрэл 196 санал буюу 62.4 хувь, Бөхчулууны Пүрэвдорж 82 санал буюу 26.1 хувь, Жудагийн Баярмаа 33 санал буюу 10.5 хувь, Бархүүгийн Отгонбат 3 санал буюу 0.95 хувийн санал авсан, нэр дэвшигч Б.Отгонбат эхний шатнаас хасагдаж, нэр дэвшигч Б.Пүрэвдорж, Ж.Баярмаа нарын хувьд дараагийн шатны санал хураалтад оролцохоос татгалзаж, нэрээ татан авсан талаар тус тус дурдаж, нэр дэвшигч О.Цогтгэрэл намын даргын сонгуульд тэргүүлснийг ҮБХ-ны Дотоод сонгуулийн хороонд өргөн мэдүүлсэн.

Ийнхүү ҮБХ-ны Дотоод сонгуулийн хорооны 12 дугаар тогтоолоор дүнг нэгтгэн албажуулж, олонхын санал авсан О.Цогтгэрэлийг Ардчилсан намын даргын сонгуульд тэргүүлснийг баталж, ҮБХ-д мэдээлж хүргүүлсэн, энэхүү тогтоолыг үндэслэн Үндэсний бодлогын хорооны 23 дугаар тогтоолоор Одонгийн Цогтгэрэлийг намын даргаар сонгогдсонд тооцож, Их хуралд өргөн мэдүүлэхээр баталсан нь хууль болон дүрмийн дээрх заалтад нийцсэн байна.

Гурав.Удирдах дээд байгууллага болох Их хурал, тус хурлаас намын даргыг ёсчлон батламжилсан талаар:

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна” гэж;

Ардчилсан намын дүрмийн 5.12.1-д “Намын эрх барих дээд байгууллага нь Ардчилсан намын Их Хурал мөн”, 5.12.3-т “Их хурлын төлөөлөгчид нь сонгогдох, томилогдох зарчмаар бүрдэх бөгөөд өөрөөр шийдээгүй бол Нийслэлд дүүргийн хороо тус бүрээс 2, аймагт 10000-аас дээш хүн амтай сумын баг бүрээс 1, бусад сумдаас тус бүр 1 төлөөлөгч сонгох ба Намын дарга, ҮБХ, ҮДХ, ДоСХ-ны гишүүд, намын дэргэдэх байгууллагын гүйцэтгэх удирдлага томилогдоно”, 5.22.5.1-д “ДоСХ нь Намын Их Хурлын төлөөлөгч, Намын дарга, ҮБХ-ны гишүүн, нийслэл, аймаг, дүүргийн намын даргын сонгууль, Ерөнхийлөгч, УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг тодруулах сонгуулийг, түүний салбар байгууллага Сонгуулийн нутаг дэвсгэрийн хороо /ДоСНДХ/, Сонгуулийн хэсгийн хороо /СоХХ/ нь нийслэл, дунд, анхан шатны намын хорооны гишүүн, нийслэл, аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийг сонгох сонгуулийг Үндсэн дүрэм, бусад журмын дагуу зохион байгуулж, дүнг нэгтгэн мэдээлэх, Үндсэн дүрэм, журамд заасан хугацаанд багтаан эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага мөн” гэж тус тус заажээ.

Өргөдөлд хавсаргасан баримтуудаас үзвэл, Ардчилсан намын Дотоод сонгуулийн хорооны 2025 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 08/01 дүгээр тогтоолоор намын Их хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг 1366 байхаар баталсан, намын Ерөнхий нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 02/147 дугаар албан бичгээр анхан, дунд болон нийслэлийн намын дарга нарт намын дүрмийн 5.12.3-т зааснаар сонгогдсон намын Их хурлын төлөөлөгчдийн мэдээллийг ирүүлэх чиглэл хүргүүлсний дагуу эдгээр байгууллагаас Их хурлын төлөөлөгчдийн нэрсийг ирүүлснээс үзэхэд, тус хуралд оролцвол зохих 1366 төлөөлөгчдөөс 897 эрэгтэй (66 хувь), 435 эмэгтэй (32 хувь) төлөөлөгч байхаар, эдгээрээс 397 нь намын Үндэсний бодлогын хороо, Дотоод сонгууль, Үндсэн дүрмийн хороо, Ахмадын холбоо, Эмэгтэйчүүдийн холбоо, Залуучуудын холбоо, Оюутны холбоог, харин 561 нь орон нутгийг, 408 нь дүүргийг тус тус төлөөлөхөөр сонгогдсон нь тухайн намын Их хуралд сонгогдох, томилогдох зарчимд үндэслэсэн байна.

2.Ардчилсан намын дүрмийн 5.12.4-т “Их хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:” гээд 5.12.4.8-д “Намын Даргыг ёсчлон батламжлах”, 5.17.2-т “Намын даргын сонгуулийг дүрмийн дагуу явуулж, намын Их Хурлаас 4 жилийн бүрэн эрхтэйгээр ёсчлон батламжилна” гэж тус тус заажээ.

Тухайн намын Их хурлын 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 08 дугаар тогтоол, хуралдааны тэмдэглэлээс үзэхэд, тухайн Ээлжит бус Их хурал нь 1250 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй хуралдаж, дийлэнх олонх буюу 1249 төлөөлөгч саналаар дэмжиж, 14 дүгээр тогтоолоор нэр дэвшигч О.Цогтгэрэлийг намын даргаар ёсчлон батламжилсан байх бөгөөд өргөдөлд хавсарган ирүүлсэн Их хурлын ирцийн бүртгэлийг шалгахад 1366 төлөөлөгч бүртгэгдсэнээс 1178 төлөөлөгч гарын үсэг зурсан нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3, намын дүрмийн 4.1, 5.12.4.8-д заасантай тус тус нийцсэн байна.

Дээрх үндэслэлээр Ардчилсан намын 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн ҮБХ-ны хурлаас намын даргыг сонгож, Ээлжит бус Их хурлаас ёсчлон батламжилсан нь Улсын төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон намын дүрмийн холбогдох заалтуудад нийцсэн байх тул тус намын даргаар О.Цогтгэрэлийг бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.6-т заасныг баримтлан Ардчилсан намын даргаар Одонгийн Цогтгэрэлийг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.5-д зааснаар Улсын дээд шүүхийн энэхүү шийдвэр нь эцсийн болохыг дурдсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Б.АМАРБАЯСГАЛАН